

Тонхил сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/96/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Цэгц богд төв аудит ХХК-ийн Аудитор: Р.Цанжидмаа

Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.23 № 60

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тонхил сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Тонхил сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар жилийн эцэст ажиллагсад улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан урамшуулал олгосон, зардлын эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийсэн, эмийн үлдэгдэлд хугацаа дууссан эмийн үлдэгдэлтэй, тендерт шалгараагүй аж ахуй нэгж байгууллагаас эм боох материал худалдан авсан, үлдэх өртөгтэй авто тээврийн хэрэгслийг акталсан, шилэн дансны цахим хуудсанд таван саяас дээш орлого зарлагын гүйлгээг мэдээлээгүй зэрэг 38,781.0 мянган төгрөгийн зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Шилэн дансны тухай хуулийн 6.4, УСНББОУС-1-тай тус тус нийцэхгүй, иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 2220 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох зардалд 547,816.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай

холбоотой зардалд 47,996.1 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авсан байна. Эрүүл мэндийн газраас 24,822.6 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, аж ахуй, хангамжийн материал үнэ төлбөргүй орлого авчээ.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 50 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 49 арга хэмжээг 90.0 хувиар, 1 арга хэмжээг 80.0 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд сумын Засаг даргаас 90.0 хувиар, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Тонхил сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Эргэлтийн хөрөнгийн дүн	226,081.71	166,768.96
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	386,466.09	371,804.70
Нийт хөрөнгийн дүн	612,547.79	538,573.66
Нийт өр төлбөрийн дүн	-	814.86
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	612,547.79	537,758.80
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	612,547.79	538,573.66
Үйл ажиллагааны орлогын дүн	10,991,965.4	6,544,026.3
Үйл ажиллагааны зардлын дүн	6,408,450.2	7,241,916.2
Үйл ажиллагааны үр дүн	4,583,515.2	(747,889.9)
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	4,583,515.2	(747,889.9)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	154,196.28	612,547.79
Тайлант оны үр дүн	458,351.52	(74,788.99)
Эцсийн үлдэгдэл	612,547.79	537,758.80
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	711,144.0	598,939.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	544,485.9	668,151.4
Үйл ажиллагааны ЦМГ	166,658.1	(69,211.6)
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(39,197.3)	(12,989.7)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	127,460.9	(82,201.3)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	127,460.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	127,460.9	45,259.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		633,145.04
Урсгал зардал		12,989.7
Хөрөнгийн зардал		620,155.34
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		633,145.04
Эрүүл мэндийн даатгалын сангаас		
		547,816.70
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,127.00
Урьд оны үлдэгдлээс		82,201.34

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 69.4 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Бараа материалын тайланд түлш шатах тослох материал 26.8 сая төгрөгийн орлого, зардлыг нөөцийн бараанд тайлагнасан.
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 17.5 сая төгрөгийн нормын хувцас, хулдаас зэргийг зарлагадсан.
- Үр дүнгийн тайланд 2.3 сая төгрөгийн зардлуудыг зөрүүтэй тайлагнасан.
- Цалингийн нэмэгдлийн төсвийн хэлбэлзэл 22.6 сая төгрөгөөр зөрүүтэй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалттай нийцэхгүй байна.

Залруулагдаагүй нийт 38.7 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 38.7 сая төгрөгийн 6 зөрчил² илэрснээс, 38.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 5 албан шаардлага, сахилгын хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Албан шаардлага

1. Зардлын эдийн засгийн ангилал зөрчин ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас төлөх 1.2 сая төгрөгийн шимтгэлийг цалингийн зардлаас төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;"-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

2. Эмийн үлдэгдэлд хугацаа дууссан 5 нэр төрлийн 1.5 сая төгрөгийн эм байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөх албан шаардлага хүргүүлсэн.

3. Тендерт шалгараагүй 1 аж ахуйн нэгж байгууллагаас 3.3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно."-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгарсан этгээдээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

4. Тухайн байгууллага нь Орон нутгийн өмчийн газарт актлах санал өгөөгүй байхад 15.0 сая төгрөгийн анхны өртөгтэй, 5.0 сая төгрөгийн үлдэх өртөгтэй УАЗ 469 авто машиныг акталж данснаас хассан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3-т "3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахад дараах журмыг баримтална." "-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгарсан этгээдээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

5. Тайлант оны цахим системд таван саяас дээш орлого, зарлагын 35.7 сая төгрөгийн 3 гүйлгээ, төсөв өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 4 шийдвэрийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.8-т "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим системд мэдээллийг мэдээлээгүй холбогдох албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

6. Ажиллагсад жилийн эцэст улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 19.2 сая төгрөгийн цалин илүү олгосон байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Тонхил сумын Эрүүл мэндийн төв	4	69.4	-	-	4	69.4	4	69.4	-	-	-	-

**Тонхил сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Дүн	4	69.4	-	-	4	69.4	4	69.4	-	-	-	-
-----	---	------	---	---	---	------	---	------	---	---	---	---

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/									
			Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Тоо			Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Тонхил сумын Эрүүл мэндийн төв	4	19.5	-	-	4	19.5	-	-	-	-	-	-
Дүн	4	19.5	-	-	4	19.5	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тонхил сумын Эрүүл мэндийн төв	2	19.3	-	-	2	19.2	-	-
Дүн	2	19.3	-	-	2	19.3	-	-
-Нийт дүн	6	38.8			6	38.8		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		